

Агуулга

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	6
3. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	9
4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	10
7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	11
8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	12
9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	14
10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	23
11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	24

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн нэр: Шохойн чулууны орд
Төсөл хэрэгжүүлэгчийн нэр: “Ам Та Тү” ХХК
Хаяг: Улсын бүртгэлийн дугаар: 711002059
Регистрийн дугаар: 2633086
Дорнод аймаг, Хэрлэн сум 10-р баг /Хэрлэн/, 27-р байр, 16-18 тоот,
Утас/факс: 99070953

ТӨСЛИЙН ХҮЧИН ЧАДАЛ

Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт орших MV-004136 тоот тусгай зөвшөөрөлтэй Аралт худаг нэртэй шохойн чулууны 26.85га талбайтай ордыг “Ам Та Тү” ХХК эзэмшдэг.

“Ляпислязурь эрдэнэ” ХХК 2018 онд “Аралт худгийн шохойн чулууны ордыг ил аргаар ашиглах техник эдийн засгийн үндэслэл”-ийг боловсруулж, Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөлийн 2018 оны 08 сарын 30-ны өдрийн Т/18-12-04 дугаартай дүгнэлт, Ашигт Малтмал, Газрын тосны Газрын 2018 оны 10 сарын 04-ны өдрийн Т/135 дугаартай тушаалаар баталгаажуулсан байна.

“Ам Та Тү” ХХК нь өөрийн эзэмшлийн ордыг түшиглэн шохой үйлдвэрлэж, Дорнод аймгийн Дашбалбар сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг “Шин шинь” ХХК-ийн уулын баяжуулах үйлдвэр, мөн аймгийн Цагаан-Овоо сумын нутагт “Степ гоулд” ХХК-ийн төлөвлөж буй Алтан цагаан овоо төсөлд нийлүүлэхээр төлөвлөжээ.

Ил уурхай

Ордын нөөц:

Түс ордод хийсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг 1976 оны 12-р сарын 29-ний өдөр БНМАУ-ын ГУУҮЯ-ны ШУТЗ-ийн хурлаар авч хэлэлцсэн №79 тоот дүгнэлтээр ордын нөөцийг бодитой ($B=748.5$ мян.тн) болон боломжтой ($C=1159.9$ мян.тн) зэргээр $B+C=1908$ мян.тн-оор улсын нөөцийн нэгдсэн санд бүртгүүлсэн байдаг.

Уурхайн хүчин чадал:

Аралт худгийн шохойн чулууны ил уурхайгаас 30.0 мян.тн шохойн чулуу олборлож, дундаж хөрс хуулалт 7.2 мян. m^3 , дундаж шохой гаралт 21.49 мян.тн байхаар жилийн хүчин чадлын төлөвлөсөн. Энэ хүчин чадлаар олборлоход ордын нөөц нь 63.1 жил хүрэлцээтэй. Ил уурхайн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, уурхайн үндсэн техник тоног төхөөрөмжийн бүтээл, жилийн хүчин чадал зэргээс ихээхэн шалтгаална. Уурхай нь 4-р сарын 1-аас эхлэн бэлтгэл ажил, засвар үйлчилгээний ажлыг 15 хоногт гүйцэтгэж, 10-р сарын 31 хүртэл жилд 210 хоног ажиллахаас баяр ёслол, цаг агаарын хүндрэл зэргийг хасвал уурхай 160 хоногт 1 ээлжээр ажиллах юм байна.

Ил уурхайн үндсэн хэмжээс: Уурхайн ёроолын түвшин 775м, ажлын доголын өндөр хөрс хуулалтад 5м, шохойн чулууны олборлолт 5м, доголын налуу 550, ажлын талбайн өргөн 20м, авто замын налуу 80% байна.

Ашиглалтын систем: Ордыг ил уурхайн аргаар ашиглах ба чулуулгийг өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараагаар экскаватор автосамосвалын хослолоор ухаж, ачих ажлыг гүйцэтгэн хөрсийг гадаад овоолгод байршуулж

шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн дэргэдэх шохойн чулууны овоолгод тээвэрлэн овоолно.

Ил уурхайг нээх: Ордыг нээх уулын ажлыг ордын урд хэсгээс буюу хайгуулын шугам III-III-ийн дагууд ил гарштай хэсгээс 805 м-ийн өндөржилтийн цэгээс траншей нэвтэрч шохойн чулууны нөөц бэлтгэн ашиглалтын ажлыг эхэлнэ.

Шимт хөрс хуулалт: Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3м-ээс ихгүй зузаантайгаар утгуурт ачигчаар хуулна. Үржил шимт хөрсийг техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх үед ашиглах зорилгоор ил уурхайн олборлолтын талбайгаас гадна талд үржил шимт хөрсний овоолгыг 2 м хүртэлх өндөртэйгөөр хийж үржил шимт хөрсийг хадгалах, арчлах, тээвэрлэлтийн стандартыг мөрдөж ажиллана.

Хөрс хуулалтын ажил: Ил уурхайн хөрсийг өрөмдлөг, тэсэлгээний аргаар сийрэгжүүлэн хуулна. Хөрс хуулалтын ажилд 1м³-ын утгуурын багтаамжтай Солонгос улсад үйлдвэрлэсэн HYUNDAI R210LC-7 маркийн гидравлик экскаватор болон 20тн даацтай HOWO маркийн БНХАУ-д үйлдвэрлэсэн автосамосвалыг тус тус ашиглана.

Шохойн чулуу олборлолт: Шохойн чулуу олборлолтын ажлыг экскаватор автосамосвалын хослолоор ухаж ачин, тээвэрлэж шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн дэргэд байрлах шохойн чулууны түр овоолгод овоолно. Хүдэр олборлолтын ажилд 1м³-ын утгуурын багтаамжтай Солонгос улсад үйлдвэрлэсэн HYUNDAI R210LC-7 маркийн гидравлик экскаватор болон 20 тн даацтай HOWO маркийн БНХАУ-д үйлдвэрлэсэн автосамосвалыг тус тус ашиглана. Уурхайн хөрс хуулалт болон шохойн чулуу олборлолтын тээвэрлэлтэд 2 ширхэг автосамосвал хүрэлцээтэй гэж тооцсон байна.

Хүснэгт 1. Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

№	Ашиглалтын жилүүд	Уулын цул	Шохойн чулуу		Хөрс хуулалт	Хөрс хуулалтын итгэлцүүр	
		мян.м ³	мян.м ³	мян.тн	мян.м ³	м ³ /тн	м ³ /м ³
1	I жил	8.30	6.15	15.25	2.15	0.14	0.35
2	II жил	12.314	10.28	25.5	2.03	0.08	0.20
3	III жил	14.24	12.10	30	2.14	0.07	0.18
4	IV жил	20.303	12.10	30	8.21	0.27	0.68
5	V жил	21.22	12.10	30	9.12	0.30	0.75
6	VI жил	19.326	12.10	30	7.2	0.24	0.60
7	VII жил	21.4	12.10	30	9.3	0.31	0.77
8	VIII жил	22.4	12.10	30	10.3	0.34	0.85
9	IX жил	22.6	12.10	30	10.5	0.35	0.87
10	X жил	22.5	12.10	30	10.4	0.35	0.86
	Дүн	184.60	113.21	280.76	71.39	0.25	0.63

Ил уурхайн үндсэн тоног төхөөрөмжид 1м³-ийн утгуурын багтаамжтай HYUNDAI-R210LC-7 маркийн урвуу утгуурт экскаватор, 20 тонны даацтай SINOTRUK HOWO автосамосвал-2 ширхэг, 120-155мм-ийн диаметртэй JK-590 маркийн өрмийн машин, 3м³ шанаганы багтаамжтай SDLG-933 маркийн утгуурт ачигч, туслах машин механизм зэргийг ашиглана.

Өрөмдлөг, тэсэлгээ: JK590 маркийн өрмийн 1 машин 1 м цооног өрөмдөхөд 13.9м³/м хөрс хуулалт, 13.9м³/м шохой сийрэгжүүлнэ. Өрмийн машины жилд гүйцэтгэх ажлын эзлэхүүн нь 114.3мян.м³/м хөрс хуулалт, 140.78 мян.м³ шохой байна.

Ил уурхайн тэсэлгээ: Тэсэлгээгээр жилд 10.9 мян.м³ хөрс хуулалт, 12.10 мян.м³ шохойн чулуу олборлоход бэлтгэх сийрэгжүүлэх ажил жилд 1-2 удаа хийнэ. Тус ажлыг Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Сайдын 2017 оны 10 марын 02-ны өдрийн А/210 дугаар тушаалаар үйлдвэрлэлийн зориулалтаар тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх 142 дугаартай тусгай зөвшөөрөл 3 жилийн хугацаатай авсан “Монмаг” ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлнэ

Шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэр

Шохой боловсруулах үйлдвэр нь жилд 30000 тн/жил хүдэр хүлээн авч 180 хоног ажиллана. боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ашиглалт 100%-тай ажиллах үед шатаах зуухны хоногийн хүчин чадал 166.7тн байна.

Шохойн хүдэр нь 1 шатлалт хацарт бутлуураар 20-80мм болтол бутлагдаж чичиргээт шигшүүрээр дамжин бутлагдсан хүдрийн бункерт орно. Тэндээс хүдэр дамжуулагчийн бункерт хүрч нүүрс дамжуулах бункерээс ирсэн нүүрстэй холигч бункерээр дамжин 7.7:1 гэсэн харьцаатайгаар жигд холин 250 м³-ийн багтаамжтай шохойн чулуу шатаах зууханд шанагат эльватороор хүргэгдэнэ. Шатаах зууханд орсон шохойн чулууны 28-29% нь өндөр температурт шаталтын улмаас СО₂-ийн хий болох бөгөөд уг хийг сорох вентиляторт соруулан шүүж хольц багатай хий ялгаруулна. Иймээс шатаан боловсруулах үйлдвэрээс хаягдал гарахгүй. Үлдэх 71-72% нь MNS 347:2002 стандартыг хангасан 1-р зэргийн шохой болно.

Дэд бүтэц:

Барилга, байгууламж: Аралт худгийн шохойн чулууны ордын барилга байгууламжийг үйлдвэрлэлийн ба ахуйн зориулалтаар тус тусад нь, уурхайн ажиллагсдын хотхоныг уурхайгаас баруун хойд зүгт 0.5 м зайд барьж байгуулахаар төлөвлөсөн байна. Уурхайн хотхонд уурхайн захиргааны байр, хоолны газар, халуун ус, ахуй үйлчилгээний байр, уурын зуух, засварын газар, авто гараж, сэлбэг материалын агуулах зэрэг барилга байгууламжууд байх ба мөн шатах тослох материалын агуулах автомашины зогсоол зэрэг багтаж байна. Барилга байгууламж болон үйлдвэрлэлийн зориулалттай объектуудыг сэндвичин угсармал хавтан хийцтэй, сэлбэг материалын агуулах зэрэгт чингэлэг ашиглана.

Дулаан хангамж: Сэрүүний улиралд ажиллах цөөн хоногт ажиллагсдын тосгон, уурхайн захиргаа, засварын барилгыг нам даралтын бага оврын зуухаар халаана.

Усан хангамж: Өөрийн гүний худгаар хангаж байна.

Цахилгаан хангамж: Төслийн цахилгаан хэрэглэгч нь уурхайн хотхон, засварын газар шатахуун түгээх станц, сэлбэгийн агуулах, шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчид байна. Нийт цахилгаан хэрэглэгчид нь харьцангуй бага чадал суурилагдсан хүчин чадалтай учраас дизель генератор ашиглахаар төлөвлөсөн байна.

Уурхайн засварын газрын болон дэд бүтцэд цахилгаан хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хангах зорилгоор 400/230В-ын хүчдэл гаргадаг, 92кВт/115кВА хүчин чадалтай ВF-C125, шохойн чулуу шатаан боловсруулах үйлдвэрийн цахилгаан хэрэглэгчдийг 120кВт/150кВА хүчин чадалтай ВF-V165 маркийн дизель цахилгаан үүсгүүрээс 0.4кВ-ын нам хүчдэлийн цахилгаан сүлжээгээр цахилгаан эрчим хүчээр хангана.


Зам, харилцаа: Тус орд нь ойролцоох сум суурин газруудтай ердийн орон нутгийн чанартай шороон замаар холбогдоно. Үйлдвэрийн болон уурхайн дотоод замууд нь байнгын усалгаа арчилгаатай уурхайн зориулалттай сайжруулсан шороон зам байна. Уурхайн талбайд үүрэн холбооны сүлжээ холбогддоггүй.

ТӨСЛИЙН БАЙРШИЛ

Аралт худаг нэртэй шохойн чулууны орд нь засаг захиргаа харьяаллын хувьд Дорнод аймгийн Чойбалсан сумын нутагт, Чойбалсан хотоос зүүн хойш 71 км, Чойбалсан сумаас хойд зүгт 21 км зайд оршино.

Хүснэгт 2. Талбайн эргэлтийн цэг

Тусгай зөвшөөрөл	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV-004136 (26.85 га)	2007-02-12	30	1	114° 48' 4.29"	48° 40' 3.96"
			2	114° 47' 39.3"	48° 40' 3.96"
			3	114° 47' 39.3"	48° 40' 20.97"
			4	114° 48' 4.29"	48° 40' 20.97"



Зураг 1. Төслийн талбайн байрлал

2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний хүрээнд 2024 онд хийж гүйцэтгэсэн ажлуудыг дараах хүснэгтээр харууллаа.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ


№	Сөрөг нөлөөллийг бууруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжүүлсэн байдал
1	Түлшний чанарын хяналт техникийн хяналт, үзлэг оношилгоог тогтмол тогтоосон хугацаанд хийж байх	Талбай дээр ажиллаж буй тээврийн хэрэгслүүд нь бүрэн бүтэн даатгал болон үзлэг оношилгоондоо цаг тухайд нь хамрагдсан.
2	Хогийн цэгийн ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж ариутгал хийж байх,	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлтэд тусгасан.
3	Зам талбайн усалгаа	Энэ жил өмнөх жилүүдийг бодоход хур бороо харьцангуй их байсан тул усалгаа хийх шаардлага гараагүй болно.
4	Нүүрсний утааг 40% бууруулах УСТ-315-4А загварын зуух суурилуулахаар төлөвлөсөн	Зуухны суурь цутгалтын ажил энэ онд хийгдсэн ба ирэх онд УСТ-315-4А загварын зуухыг оруулж ирэхээр төлөвлөсөн.
Хөрсөн бүрхэвч		
1	Шимт хөрсийг стандартын шаардлагын дагуу хадгалж, хамгаалах	Шимт хөрсийг 15 см зузаантай хуулж Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу овоолго үүсгэсэн
2	Авто засварын талбайг хатуу хучилттай болгох	Энэ жилийн хувьд авто засварын газар байгуулагдаагүй ба авто машин нь аймгийн төв дээр байрлах эрх бүхий албан байгуулга дээр засвар үйлчилгээгээ хийлгэсэн.
3	Ажилчдын байр барихад шимт хөрсийг стандартын дагуу хуулах	2023 онд Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт хадгалалт MNS 5916:2008 стандартын дагуу овоолго үүсгэсэн.
4	Барилгын материалыг эмх цэгцтэй хураах	энэ онд шинээр овоолго үүсгээгүй.
5	Хөрсний шинжилгээ хийлгэсэн	Нарт ШУҮН консалтинг ХХК-ийн хөрсний лабораторид шинжилгээг хийлгэсэн.
Усны нөөц		
1	Ус ашиглах гэрээг байгуулах	Сумын засаг даргатай ус ашиглах гэрээ 2024 оны 10 сарын 15-ны өдөр байгуулсан /гэрээг хавсаргав/
Дуу чимээ		
1	Тэсэлгээ хийхдээ ойр орчимд мэдэгдэл өгч, аюулгүй ажиллагааны дүрэм журмыг баримталж ажиллах	Энэ жил тэсэлгээ хийгдээгүй болно.



Зураг 2. Зам талбайг засаж буй байдал



Зураг 3. Шимт хөрсний овоолго



Зураг 4. Ажилчдын кемпийн барилгын ажлын үйл явц



Зураг 5. Замын тэмдэг байршуулсан байдал

3. НӨХӨН СЭРГЭЭЛТ, ТОХИЖИЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2024 онд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Чойбалсан сумын ЗДТГ-аас өгсөн саналын дагуу 70 ширхэг Агч модыг нөхөн тарилт хийж, мод тарьсан талбайг хашиж хамгаалсан.



Зураг 6. Мод тарьсан байдал 06 сар

2024 онд уурхайн тосгоны тохижилтод 55ш улиас мод тарьж орчны тохижилтыг сайжруулсан.



Зураг 7. Мод тарьсан байдал 10 сар

4. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хамжихгүй бол амжихгүй аяны хүрээнд 3 сараас 6 сар хүртэл 3 удаагийн үйл ажиллагаагаар багийн бүх зудад нэрвэгдсэн малын сэг зэмийг цэвэрлэж, булах ажил хийсэн мөн өвөлжилт хүндэрч зам хаагдсан нөлөөллийн бүсэд зам гаргах ажлыг хийсэн.



Зураг 8. Сэг зэм булж буй байдал болон зам гаргаж буй зураг

5. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Энэхүү төслийн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн шилжүүлэх ажил хийгдэхгүй.

6. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төсөл хэрэгжих орчинд сүм суурин газар олон жил үйл ажиллагаа явуулсан, тэмдэглэгдэж бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйл сумын төвийн тухайн орчинд байхгүй.

7. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө


Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Нийт зардал	Тайлбар
Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	Аюулгүй байдал аваар ослын тэмдэг тэмдэглэгээг байршуулж аюулгүй ажиллагааны зөвлөмж зааварчилгааг тогтмол өгдөг.
Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх		
Гал түймрээс урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тодорхой цэгүүдэд байрлуулах		Тодорхой цэгүүдэд байршуулсан

Сургалт хийж буй байдал: Сургалт, ухуулга, ХАБЭА-н сургалтыг тогтмол зохион байгуулж байна.



Зураг 9. Галын сараа болон сургалтад хамрагдаж буй байдал

Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журмыг батлан мөрдөж ажилласан.



Зураг 12. Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам

8. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 5. Хог хаягдлын биелэлт


№	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ	Зардал, төгрөг
1	Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх	Мэдээлэл сурталчилга тогтмол хийж, ажилчдад хэвшил болгон, тэмдэг тэмдэглэгээ хийсэн.
2	Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх	Хог хаягдал зайлуулах гэрээг Чойбалсан сумын ЗД-тай гэрээ байгуулсан./Хавсаргав/
3	Ангилсан хог түр хадгалах цэг тохижуулах	Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн цэгийг байгуулсан ба ариутгал халдваргүйжүүлэлт хийн гэрээний дагуу хог хаягдлаа зайлуулж байна.
4	Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн цэгийг битүүмжлэн байгуулах	

Хог ангилан ялгах зорилгын хүрээнд хог 3 янзаар ангилах хогийн сав байршуулж 2 дугаарт хуванцрыг тусгайлан цуглуулж/ундаа, ус, тос масло, гидрийн шингэн, хропны тосны сав, угаалгын нунтаг, аяга угаагч гэх мэт/ Дорнод аймгийн Баянтүмэн төмөр замын салбарт тушаасан.



Зураг 13. Түр хадгалах хог хаягдлын цэг

Төслийн талбайн ойр орчин дахь хогийг ажилчид 7 хоногт 1 удаа их цэвэрлэгээ хийн түүж хогийн нэгдсэн цэгт хаясан.



Зураг 14. Цэвэрлэгээ хийж буй байдал

Хатуу шингэн хог хаягдлын цэгүүдэд ариутгал, халдваргүйжүүлэлт тогтмол хийсэн.



Зураг 15. Халдваргүйжүүлэлт хийж буй байдал

9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Хүснэгт 6. Шинжилгээ хийсэн үзүүлэлт, сар өдөр

№	Хяналт шинжилгээ явуулсан үзүүлэлт	Шинжилгээ хийлгэсэн лаборатори	Хугацаа
1	Хөрсөнд бохирдлын үзүүлэлт	“Нарт ШУУН” лаборатори	2024.06.27 2024.10.22
2	(Агаарын даралт, гПа, Агаарын температур, С, Хүхэрлэг хий, мг/м ³ , Нийт тоосны агууламж /TSP/, мг/м ³ , Азотын давхар исэл мкг/м ³) шинжилгээ,	БОХЗТ лаборатори	2024.06.27
3	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	“Нарт ШУУН” лаборатори	2024.06.27 2024.10.22

Хүснэгт 7. Төслийн талбайн хэмжилтийн үр дүн

№	Цэгийн нэр	Сорьц авсан өдөр	Хүхэрлэг хий мкг/м ³	Азотын давхар исэл мкг/м ³	Нийт тоос	Агаарын даралт	Агаарын температур
			мкг/м ³	мкг/м ³	мкг/м ³	гПа	°C
1	Ажилчдын кемп	VI/27	5	2	9	687.9	29.4
2	Зүүхны ам орчимд	VI/27	5	5	168	687.7	31.1
3	Аралт худгийн уурхайн карьер	VI/27	7	7	10	687.4	29.8
4	Уурхайн орд	VI/27	6	7	12	687.2	30.7
Агаарын чанарын стандарт MNS 4585:2016 /20 минут хэмжилт/			450	200	50	-	-





Зураг 16. Агаарын хэмжилт хийж буй байдал

Хүснэгт 8. Хөрсний химийн үндсэн шинж

№	Гүн, см	pH	Давс %	ЦДЧ dsm	Ялзмаг, %	CaCO ₃ %	NO ₃ мг- 100 гр	Солилцох суурь, мг-экв/100 гр		Шим тэжээлийн элементүүд мг/100 гр	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
6 сар											
Дээж 1											
1	0-20	8.01	0.016	0.039	2.71	0.00	0.14	19	9	2.3	8
2	20-40	7.30	0.024	0.058	2.68	0.00	0.22	20	8	1.4	2
Дээж 3											
3	0-30	8.06	0.019	0.047	2.46	0.00	0.17	18	6	2.0	2
10 сар											
Дээж 4											
1	0-20	8.41	0.118	0.290	2.95	0.0	1.16	18	3	1.4	10

Хөрсөн дэх химийн үндсэн шинжээс дүгнэвэл дээж авсан цэгийн хувьд хүчтэй хүчиллэг урвалын орчинтой, карбонатгүй, ялзмагийн агууламж маш бага, үржил шимийн үзүүлэлт болох хөдөлгөөнт суурь ($P_2O_5 + K_2O$)-ийн нийлбэр 3.4-11.4мг/100гр буюу шим тэжээлийн үзүүлэлт хангалттай байна. Цахилгаан дамжуулах чанар бага буюу давсжилтгүй байна.

Хүснэгт 9. Хөрсний ширхгийн хэмжээ, механик бүрэлдэхүүн

гүн, см	Механик ширхгүүд, %, ширхгийн хэмжээ, мм							Механик бүрэлдэхүүн
	1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01	
6 сар								
Дээж 1								
0-20	10.9	62.1	12.5	7.3	1.9	5.3	14.5	Элсэнцэр
20-40	8.6	58.9	16.2	9.5	2.2	4.6	16.3	
Дээж 3								
0-30	13.2	62.8	8.9	8.1	2.8	4.2	15.1	Элсэнцэр
10 сар								
Дээж 4								
0-20	8.3	57.4	16.2	9.5	3.2	5.4	18.1	Элсэнцэр

Хөрсний механик бүрэлдэхүүний задлан шинжилгээний дүнгээр Элсэнцэр механик бүрэлдэхүүнтэй хөрстэй байна.

Хүснэгт 10. Хөрсний эрүүл ахуйн шинжилгээний дүн

Дээжийн дугаар	Нянгийн тоо MNS 6341:2012	Гэдэсний савханцрын титр (E.coli)MNS 5367:2004		Анаэробын (Cl.perfringens) MNS 6341:2012	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж-4 /6сар/	$7.3 \cdot 10^5$	0.01	2	>0.1	1
Дээж-3/10сар/	$3.3 \cdot 10^5$	0.01	2	>0.1	1

Эрүүл ахуйн үзүүлэлтүүд “Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ” (MNS 3297:2019)-ийн стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй буюу хэвийн хэмжээнд байна.

Хүснэгт 11. Хөрсөн дэх хүнд металлын агууламж

Дээжийн дугаар	Гүн, см	Хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr/хром/	Pb/хартугалга/	Cd/кадми/	Zn/цайр/	Cu/зэс/	Ni/никель/
/06-р сар/							
1	0-20	42.0	52.5	0.0	42.5	20.1	7.7
2	0-10	32.0	50.0	0.0	34.6	13.9	4.8
3	0-30	49.5	48.4	0.0	55.4	18.5	12.9
4	0-20	55.6	49.9	0.0	60.6	21.5	14.2
/10-р сар/							
1	0-10	42.2	22.3	0.0	40.6	36.85	3.05
2	0-10	33.35	11.35	0.0	62.0	38.15	4.55
3	0-10	41.1	25.9	0.0	45.05	38.8	5.3

Шинжлүүлсэн элементүүдийн хувьд “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” (MNS 5850:2019)-ийн стандартын хүлцэх агууламжаас давсан үзүүлэлт байхгүй буюу хэвийн хэмжээнд байна.



Зураг 17. Дээж авч буй үеийн зураг

Усны чанар:

Хүснэгт 12. Худгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт/Ам та тү ХХК/

анион	мг/л	мг/экв	мг-экв/л	катион	мг/л	мг/экв	мг-экв/л
Cl ⁻	45.94	1.29	13.15	Na ⁺ +K ⁺	105.27	4.58	44.72
SO ₄ ⁻	73.26	1.53	15.51	Ca ⁺⁺	45.55	2.28	22.25
NO ₂ ⁻	0.1	0.00	0.02	Mg ⁺⁺	40.38	3.37	32.88
NO ₃ ⁻	0.74	0.01	0.12	NH ₄ ⁺	0	0.00	0.00
CO ₃ ⁻	13.5	0.31	3.12	Fe ⁺⁺	0.29	0.01	0.14
HCO ₃ ⁻	408.8	6.70	68.09	Fe ⁺⁺⁺	0	0.00	0.00
Дүн	542.34	9.84	100.00	Дүн	191.49	10.23	100.00

Анион катионуудын нийлбэр: 733.83 мг/л

HCO₃⁻ ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 529.43 мг/л

Хуурай үлдэгдэл: 562.0 мг/л

Ерөнхий хатуулаг: 5.6 мг-экв/л

pH 8.07

Исэлдэх чанар: 9.28 мг/л

Усны найрлагын томъёо

$$M_{(0.7\text{мг/л})} = \frac{\text{HCO}_3 68 \text{ SO}_4 15 \text{ Cl } 13}{\text{Na+K } 44 \text{ Mg } 32 \text{ Ca } 22}$$

Хүснэгт 13. Зарим элементүүдийн шинжилгээний дүн

№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн	№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн
1	Mn	0.1	0.02	12	Ba	0.7	0.03
2	Ni	0.02	<0.005	13	Be	0.0002	<0.001
3	Cu	2.0	<0.02	14	Se	0.04	<0.01
4	Cd	0.003	<0.001	15	Hg	0.001	<0.001
5	Co	-	<0.001	16	Sr	2.0	1.05
6	Pb	0.01	0.01	17	Mo	0.07	0.007
7	Zn	5.0	<0.01	18	As	0.01	<0.01
8	Cr	0.05	<0.005	19	Sb	0.02	<0.01
9	Al	0.5	<0.025	20	CN _{free}	0.01	<0.002
10	Ag	0.1	<0.01	21	Fe	0.3	0.29
11	B	2.4	0.19	22	U	0.03	<0.10

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу харьцангуй ихэвтэр эрдэсжилттэй, хатуувтар ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүдээс Mg/Магни/ нь “Хүрээлэн буй орчин. эрүүл мэндийг хамгаалах. аюулгүй байдал. ундны ус. эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй байна.

Хүснэгт 14. Худгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт/иргэн Наранболд/

анион	мг/л	мг/экв	мг-экв/л	катион	мг/л	мг/экв	мг-экв/л
Cl ⁻	22.12	0.62	7.57	Na ⁺ +K ⁺	100.96	4.39	51.79
SO ₄ ⁻	27.42	0.57	6.94	Ca ⁺⁺	39.04	1.95	23.03
NO ₂ ⁻	0	0.00	0.00	Mg ⁺⁺	25.57	2.13	25.14
NO ₃ ⁻	1.75	0.03	0.34	NH ₄ ⁺	0	0.00	0.00
CO ₃ ⁻	13.5	0.31	3.73	Fe ⁺⁺	0.05	0.00	0.03
HCO ₃ ⁻	408.8	6.70	81.42	Fe ⁺⁺⁺	0	0.00	0.00
Дүн	473.59	8.23	100.00	Дүн	165.62	8.47	100.00

Анион катионуудын нийлбэр: 639.21 мг/л

HCO₃⁻ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 434.81 мг/л

Хуурай үлдэгдэл: 454.0 мг/л

Ерөнхий хатуулаг: 4.05 мг-экв/л

pH 8.25

Исэлдэх чанар: 3.76 мг/л

Усны найрлагын томъёо

$$M_{(0.1\text{мг/л})} = \frac{\text{HCO}_3 81 \text{ Cl } 7 \text{ SO}_4 7}{\text{Na+K } 51 \text{ Mg } 25 \text{ Ca } 23}$$

Хүснэгт 15. Зарим элементүүдийн шинжилгээний дүн

№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн	№	Үзүүлэлт	ЗДХ	Үр дүн
1	Mn	0.1	<0.01	12	Ba	0.7	<0.01
2	Ni	0.02	<0.005	13	Be	0.0002	<0.001
3	Cu	2.0	<0.02	14	Se	0.04	<0.01
4	Cd	0.003	<0.001	15	Hg	0.001	<0.001
5	Co	-	<0.001	16	Sr	2.0	0.29
6	Pb	0.01	0.01	17	Mo	0.07	<0.005
7	Zn	5.0	<0.01	18	As	0.01	<0.01
8	Cr	0.05	<0.005	19	Sb	0.02	<0.01
9	Al	0.5	<0.025	20	CN _{free}	0.01	<0.002
10	Ag	0.1	<0.01	21	Fe	0.3	0.05
11	B	2.4	0.1	22	U	0.03	<0.10

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, холимог бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд нэн цэнгэг буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөвтөр ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин. эрүүл мэндийг хамгаалах. аюулгүй байдал. үндны ус. эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна.

Төслийн ус хэрэглээг хангадаг худгаас 10 сард дээж авч “Нарт ШУҮН” лабораторид ерөнхий химийн шинжилгээ хийлгэсэн дүнг дараах хүснэгтээр харуулж байна.

Хүснэгт 16. Худгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт

анион	мг/л	мг/экв	% мг-экв/л	катион	мг/л	мг/экв	% мг-экв/л
Ca ⁺⁺	78.0	3.89	37.00	CO ₃ ⁻	5.00	0.08	0.79
Mg ⁺⁺	36.0	2.96	28.16	HCO ₃ ⁻	492.0	8.06	76.66
Fe	0.0	0.0	0.0	Cl ⁻	62.0	1.75	16.63
K ⁺	14.0	0.36	3.41	SO ₄ ⁻	26.0	0.54	5.15
Na ⁺	76.0	3.31	31.43	NO ₃ ⁻	5.0	0.08	0.77
Дүн	204.0	10.52	100.00	Дүн	590.0	10.52	100.00

Анион катионуудын нийлбэр: 794 мг/л

HCO₃⁻ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 548 мг/л

Хуурай үлдэгдэл: 532 мг/л

Ерөнхий хатуулаг: 5.85 мг-экв/л

pH: 8.10

Исэлдэх чанар: -1.289 мг/л

Усны найрлагын томьёо

$$M_{(0.79\text{мг/л})} = \frac{\text{HCO}_3 \text{ 77 } \{ \text{Cl } 17 \text{ SO}_4 \text{ 5} \}}{\text{Ca}37 \text{ Na}31 \text{ Mg } 28}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу ихэвтэр эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин. эрүүл мэндийг хамгаалах. аюулгүй байдал. үндны ус. эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна

Цагаан дэрсний худаг:

Хүснэгт 17. Худгийн усны химийн шинжилгээний тодорхойлолт

анион	мг/л	мг/экв	% мг-экв/л	катион	мг/л	мг/экв	% мг-экв/л
Ca ⁺⁺	44.0	2.20	30.51	CO ₃ ⁻	4.00	0.07	0.93
Mg ⁺⁺	42.0	3.46	48.01	HCO ₃ ⁻	380.0	6.23	86.43
Fe	0.0	0.0	0.0	Cl ⁻	30.0	0.85	11.75
K ⁺	6.0	0.15	2.14	SO ₄ ⁻	0.0	0.0	0.0
Na ⁺	32.0	1.39	19.34	NO ₃ ⁻	4.0	0.06	0.90
Дүн	124.0	7.20	100.00	Дүн	418.0	7.20	100.00

Анион катионуудын нийлбэр: 542 мг/л

HCO₃⁻ийн хагасыг хассан анион катионуудын нийлбэр: 352 мг/л

Хуурай үлдэгдэл: 335 мг/л

Ерөнхий хатуулаг: 5.66 мг-экв/л

pH: 8.13

Исэлдэх чанар: -0.798 мг/л


Усны найрлагын томъёо

$$M_{(0.54\text{мг/л})} = \frac{\text{HCO}_3 \ 86 \ \{ \text{Cl} \ 12 \}}{\text{Mg} \ 48 \ \text{Ca} \ 31 \ \text{Na} \ 19}$$

Химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, магнийн бүлгийн, 3-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу ихэвтэр эрдэсжилттэй, бага хатуулагтай ус байна. Шинжилсэн үзүүлэлтүүд нь “Хүрээлэн буй орчин. эрүүл мэндийг хамгаалах. аюулгүй байдал. үндны ус. эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандартын шаардлага хангаж байна



Зураг 18. Дээж авах үеийн зураг



Зураг 19. Дээжлэлт хийсэн цэгүүдийн байршил

10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Биелэлт
1.	Байгаль орчны болон хөдөлмөрийн аюулгүй байдлын харилцааг зохицуулах дотоод дүрэм, журамтай болох	Журам боловсруулсан мөрдөж ажилласан.
2.	Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаар 1 жилд 2 удаа сургалт сурталчилгааны ажлыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулна.	ХАБЭА төлөвлөгөө, Галын аюулгүй байдлыг хангах журмуудыг боловсруулан ажилчдад сургалт тогтмол зохион байгуулсан.
3.	Төслийн үйл ажиллагааны хэрэгжилтэд байгаль орчны төлөвлөгөөт аудитыг хийлгэх	2024.06.27-ний өдөр “Энвайроменал Комплайнц”ХХК-иар хийлгэсэн
4.	Галын дүгнэлт гаргуулах	-
5.	Тэр бум мод үндэсний хөдөлгөөнд Чойбалсан сумын ЗДТГ-тай хамтран нөхөн тарилт болон хашаажуулах	Нөхөн сэргээлт, тохижилтын төлөвлөгөөний биелэлт тусгасан.
6.	Хэрлэн голын сав газрын захиргаатай хамтран Усны өдрийг зохион байгуулах хамтран ажиллах	Дэлхийн усны өдөрт зориулж Хэрлэн голын сав газартай хамтарч эссэ бичлэгийн уралдаан зохион байгуулсан.

11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Нийгмийн хариуцлагын хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлууд

1. Өвөлжилт хүндэрч зам гаргах ажлыг нөлөөллийн бүсэд хийсэн
2. Хамжихгүй бол амжихгүй аяны хүрээнд 3 сараас 6 сар хүртэл 3 удаагийн үйл ажиллагаагаар багийн бүх сэг зэмийг цэвэрлэж, булах ажил хийсэн
3. Дэлхийн усны өдөрт зориулж Хэрлэн голын сав газартай хамтарч эсээ бичлэгийн уралдаан зохион байгуулсан.
4. Ахмадын баярт Сүмбэр багийн 30 ахмадад хүндэтгэл үзүүлэв.
5. Сүмбэр багийн иргэдэд 150 тонн нүүрсийг өгсөн.
6. Малчдад сэтгэл санааны дэмжлэг үзүүлж малаа алдсан өрхүүдэд будаа, гурил тараасан.



Зураг 20. Ахмадад хүндэтгэл үзүүлж буй байдал

БАТЛАВ БАЙГАЛЬ ОРЧНЫ АЖЛАХ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Х. АНТУЛГА "УС-БА ЭНХТАЙВАН" СЭДЭВТ ЭСЭЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ 2024.02.27 Чойбалсан хот Нээ. Үйлдвэрлэл: Жил бүрийн 03 дугаар сарын 22-ны өдөр буюу "Дэлхийн Усны өдөр"-ийг Монгол Улсын хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлсээр ирсэн. Нэгдсэн үндэстний Байгууллагаас 2024 оны "Дэлхийн Усны өдөр"-ийг "Water for People" уриан дор тэмдэглэхээр зарласан байна. Дорнод аймгийн Байгаль орчны салбарын байгууллагууд хамтран "Ус ба Энхтайвн" сэдэвт эсээ бичлэгийн уралдааныг Дорнод аймгийн нийт 14 сумын ЕБС-ийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж байна. Хойр. Зорилго: Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын экологийн боловсролыг дээшлүүлэх, ус, усан орчинг хайрлан хамгаалах, усыг зөө зохистой ашиглах, эхмэн сэтгэлгээг төлөвшүүлж, усны үнэ цэнэ болон шинжлэх ухаан танин мэдэхүйн мэдлэгийг хамтатган эзэмшүүлэх, тэдний судлан шинжлэх, дүн шинжилгээ хийх, бичих, найруулах ур чадварыг хөгжүүлэхэд оршино. Гурав. Хамрах хүрээ: Дорнод аймгийн 14 сумдын ЕБС-ийн 9-12 дугаар ангийн сурагчид. Дөрөв. Тавигдах шаардлага: • Үндсэн агуулгын хүрээнд бичсэн байх. • Бодит баримт, жишээн дээр тулгуурласан байх. • Тулгамдаж буй асуудлыг илэрхийлсэн, шийдлийг тусгасан байх. • Монгол хэлээр 250-300 үгэнд багтаан үг үсэг, дүрмийн болон утга найруулганыг алдаагүй бичигдсэн байна. • А4 цаасан дээр зүүн талас 3 см, баруун талас 1.5 см, дээд болон доод талас 2 см зайтай, мөр хоорондын зай 1.5 см байх бөгөөд А4-ийн 12 үсгийн фонтоор бичнэ. • Эсээ бичлэгийн доод талд өөрийн овог нэрийг бүтнээр бичих, сум, сургууль, анги, бүлэг, утасны дугаарыг бичнэ. Тав. Материал хүлээн авах хувицаа: Материалыг 03-р сарын 09-ны өдөр хүртэл хүлээн авна. Материалыг dornodbog@gmail.com хаягаар pdf файлаар хүлээн авна. Зургаа. Шалгаруулалт:	Материалыг хүлээн авч 03-р сарын 09-ны өдөр хянан баталгаажуулж хариуг хүргүүлнэ. 03-р сарын 12-ны өдөр Дорнод аймгийн Политехник коллежийн зааланд гардуулна. Долоо. Шагнал, урамшуулал: I –р байр ерөмжлөл, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл II –р байр ерөмжлөл, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл III –р байр ерөмжлөл, мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл Найм. Ерөнхий зохион байгуулагч: • Байгаль орчин, аялал жуулчлалын газар Ес. Хамтран зохион байгуулагч: • Хэрлэн голын сав газрын захиргаа • Буйр нуур-Мэнхнийн талын сав газрын захиргаа • Ус, цаг уур орчны шинжилгээний төв • Буйр нуурын экосистемийг хамгаалах, аялал жуулчлалыг хөгжүүлэх төв ОНӨААТҮГ • "Ам Та Тү" ХХК Арав. Холбоо барих: Дэлгэрэнгүй мэдээллийг доорх цахим хаягаар лавлана уу. dornodbog@gmail.com, tserevargasai396@gmail.com Утас: 80088994, 91075757
---	--

Зураг 21. эсээ бичлэгийн уралдааны удирдамж



Зураг 22. Нүүрс тарааж буй байдал



Зураг 23. Гурил будаа тарааж буй байдал

Хавсралт:

1. Улсын бүртгэлийн гэрчилгээ
2. Тусгай зөвшөөрөл
3. Ус ашиглах гэрээ
4. Хог хаягдлын гэрээ
5. Шинжилгээний хариунууд

УБ-2	Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 20 дугаар тогтоолоор батлав.	
		
МОНГОЛ УЛС УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ		
2005.11.15 /Бүртгэсэн он, сар, өдөр/	711002059 /Улсын бүртгэлийн дугаар/	
	2633086 /Регистрийн дугаар/	
Ам Та Тү	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	
/Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр/		
Үүсгэн байгуулагч /Үүсгэн байгуулах баримт бичиг/		
шийдвэр /шийдвэрийн нэр/	1 /дугаар/	1999.11.12 он, сар, өдөр
269400 /код/	Байгалийн шохойн үйлдвэрлэл /Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл/	
551000	Зочид буудал	
552000	Зочигийн газар	
511001	Гадаад, дотоод худалдаа	
154100	Талх, талхэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	
523400	Барилгын материалын жижиглэн худалдаа	
/код/	/Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл/	
Хугацаагүй хугацаа	1 /жишүүдийн тоо/	5,450.0 /өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр/
Дорнод, Хэрлэн, 10-р баг /Хэрлэн/, 27 байр - 16-18 тоот, утас1:23487, утас2:91588799, факс		
/хуулийн этгээдийн албан ёсны хаяг/		
		
Дорнод аймгийн татварын хэлтэс /бүртгэсэн байгууллагын нэр/		

Харилцах банкны бүртгэл:

Харилцагч банкны нэр	Дансны төрөл	Дансны дугаар	Бүртгэсэн ажилтан, тэмдэг
ХХБ Дорнод салбар	Төгрөгийн	401009156	Л.Цэвэлсүрэн

Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн бүртгэл:

Д/д	Нэмэлт, өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан, тэмдэг
1	М.т.х-ийн татварын бүртгэл хангагдав	2014.04.30	Л.Цэвэлсүрэн
2	Зоос Дорнод ТТ 2416071904 тоот төгрөгийн дансыг бүртгэв.	2009.10.13	Л.Цэвэлсүрэн
2	Д-рмийн гэрээ 23,000 0-и-г хэвдэж 29,000 0-и-г өргөтгөснөөс болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2011.03.16	Б.Болор-Эрдэнэ
3	ХАА Дорнод салбар банкны 5422125403 тоот төгрөгийн дансыг бүртгэв.	2014.02.19	Б.Болор-Эрдэнэ
4	Доржсатов овогтой Жанлаа -г Ерөнхий захирал-р томилсныг бүртгэв.	2005.11.15	Л.Цэвэлсүрэн
5	Хувь нийлүүлэгчээс 0 хэсэгдэж үүсгэн байгуулагчийн тоо нийлж 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2018.09.27	Б.Болор-Эрдэнэ
6	Бадарч овогтой Отоонбаатар -г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв.	2018.09.27	Б.Болор-Эрдэнэ

